БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫГ ТУНХАГЛАСНЫ 50 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНИЙ БЭЛЭГ БОЛГОН БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСАД ХЭД ХЭДЭН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ БАРЬЖ БАЙГУУЛАХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН

# ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар,

социалист интернационализмын зарчимд тулгуурласан уламжлалт ах дүүгийн найрамдал, бүх талын хамтын ажиллагааны харилцааг үндэслэн,

монгол, зөвлөлтийн ард түмний ах дүүгийн холбоог хэлбэрэлтгүй бэхжүүлэх эрмэлзэлийг удирдлага болгон, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үйлдвэрлэх хүчний өсөлтийг хурдатгах, монголын ард түмний аж байдал, соёлын хэмжээг цаашид дээшлүүлэх явдалд туслалцаа үзүүлэхээр,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхагласны 50 жилийн ойг ёслон тэмдэглэж байгааг тохиолдуулан

дор дурдсан зүйлээр тохиролцов:

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар нь зөвлөлтийн ард түмнээс монголын ард түмэнд бэлэг болгон өгч байгаа дараах барилга байгууламжийг зөвлөлтийн байгууллагуудын хүч, хөрөнгөөр 1976-1980 онд барьж байгуулах явдлыг хангана. Үүнд:

100 мянган хавтгай дөрвөлжин метр сууцны талбай бүхий орон сууцыг соёл-ахуйн барилга байгууламжийн хамт;

тус бүр жилд 70 мянган хавтгай дөрвөлжин метр сууцны талбай бүхий орон суурцны байшин үйлдвэрлэх хоёр комбинат;

шинжлэх ухаан, техник, соёлын Ордон;

гэрлэх ёслолын Ордон;

шинжлэх ухаан, техник, соёлын ажилтнуудад зориулж Улаанбаатар хотод 130-150 айлын суууцыг тус тус барина.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Монголын Тал энэ Хэлэлцээрт заасан барилга байгууламжийг барихад бүх талын туслалцаа үзүүлнэ.

Монгол, зөвлөлтийн эрх бүхий байгууллагууд барилга байгууламжийг барих тодорхой нөхцөл болон энэ Хэлэлцээрт дурдсан соёл-ахуйн барилга байгууламжийн бүрэлдэхүүнийг тохиролцоно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Энэ Хэлэлцээр гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Үүнийг 1974 оны арван нэгдүгээр сарын "27"-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, орос хэл дээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд хоёр эх хувь адил хүчинтэй болно.

| | |
|---|---|
| БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ ОЛГОСНООР | ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ ОЛГОСНООР |
| Д. Майдар | [signature] |